

## ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН МОНГОЛ ХЭЛ, СОЁЛЫН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын төр, Засгийн газраас хилийн чанад дахь монгол иргэд, тэдний үр хүүхдийн монгол хэл, соёлын боловсролд ихээхэн анхаарч байна. Тухайлбал, УИХ-аас баталсан Боловсролын багц хуулиуд, “Монгол хэлний тухай хууль”-д дээрх асуудалтай холбогдох зүйл заалт бүхий нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Түүнчлэн Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт холбогдох заалтыг тусган хэрэгжүүлж байна.

Мөн дэлхийн 100 гаруй оронд ажиллаж, амьдарч байгаа 130 мянган Монголчууд өөрсдийн санаачилгаар эвлэлдэн нэгдэж, монгол хэлний сургалтын төв, сургууль байгуулж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Тэд хилийн чанадад ажиллаж, сурч, амьдарч буй монгол иргэдийн хүүхдүүд оршин суугаа орныхоо сургуульд харь хэлээр боловсрол эзэмшиж, монгол хэлээ сурах бололцоо нөхцөлөөр хомс, монгол хэлээ мартаж, хэрэглэхгүй, сурахгүй өсөж байгаа нь эмзэг асуудал гэж үзэж байна.

“Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөл” төрийн бус байгууллагын Боловсролын Хорооноос хийсэн судалгаагаар дэлхийн 16 оронд нийт 48 монгол хэл, соёлын сургалтын байгууллага бүртгэгдэж, үйл ажиллагаагаа явуулж байна.<sup>1</sup> Гэвч эдгээр сургалтын байгууллагад суралцаж буй хүүхдэд зориулсан монгол хэл, бичиг, соёлын сургалт хөтөлбөр, гарын авлага одоогоор алга байна. Иймд хилийн чанадад ажиллаж буй сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулах шаардлага байна.

Энэхүү сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулахад Хилийн чанад дахь Монголчуудын холбооны Боловсролын хорооны гишүүд оролцож байгаа болно. Мөн хөтөлбөрийн төслийг холбогдох сонирхлын бүлгүүдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Сургалтын хөтөлбөрийн зорилго нь хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдэд эх хэл, бичиг, үндэсний соёл, урлаг, ёс заншил, өв уламжлалаас суралцаж, эх орноороо бахархах, эх хэл, түүх, соёлоо эрхэмлэн дээдлэх үзэл, хандлагатай болоход нь хувь нэмэр оруулахад оршино.

*Хамрах хүрээ:* Хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдүүд

*Хөтөлбөрийн зорилт:* Хөтөлбөрийг 3 шаттай хэрэгжүүлж, дараах зорилтыг хангана.

- Кирил үсгийн цагаан толгойд тайлагдаж, монгол хэлээр уншиж бичиж сурах;


---

<sup>1</sup> Энэхүү бүртгэл нь тус хорооноос 2017 оны 3 сарын байдлаар шинэчилсэн бүртгэл болно.

- Эх хэлээрээ ярих, бичих, унших зохих чадвартай болох, цаашид монгол хэл, соёлоо бие даан судлах, суралцах арга барил эзэмших;
- Монгол эх орон, үндэсний ёс заншил, түүх, соёл, аман болон бичгийн уран зохиол, эд өлгийн үнэт зүйлсийн талаар уншиж танилцах;
- Монгол ёс заншил, өв уламжлалаас сурч мэдэж, өдөр тутмын амьдрал ахуй, харилцаандаа хэрэгжүүлж хэвшил дадал болгох;

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Зураг. Сургалтын хөтөлбөрийн шатлал, агуулга



	<i>“Ярих-сонсох” чадвар</i>		
	<i>Анхан</i>	<i>Дунд</i>	<i>Ахисан</i>
<i>Зөв сонсох, ярих</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол хэлний авиа, үсэг, үе, үг, өгүүлбэрийг сонсох, зөв, тод дуудах, хэлэх</li> <li>- Үг, холбоо үг, өгүүлбэрийн аялга, дуудлагыг зөв хэлэх</li> <li>- Юмс үзэгдлийг заан ангилж нэрлэх, хэлэх</li> <li>- Асуултад хариулах</li> <li>- Сэдвийн хүрээнд ойлгомжтой ярих</li> <li>- Зөв бүтэцтэй, богино өгүүлбэрээр ярих</li> <li>- Амьдарч байгаа улс, хот, гэр бүл, найз, өөрийнхөө тухай танилцуулах</li> <li>- Шүлэг, зүйр цэцэн үг, түргэн хэллэг чээжлэх, хэлэх</li> <li>- Мэндлэх, хүндлэх, талархах, уучлах, хүсэх, хүндэтгэлийн үг, бэлэг дэмбэрлийн үг хэлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол хэлний үсэг, үе, үг, өгүүлбэрийг зөв, тод дуудах, сонсох, хэлэх</li> <li>- Урт, богино, хос эгшгийг ялгаж сонсох, хэлэх</li> <li>- Үг, холбоо үг, өгүүлбэр, бичил эхийг зөв дуудах</li> <li>- Бусдад өөрийн санааг чөлөөтэй илэрхийлэх</li> <li>- Зөв бүтэцтэй, бүтэн өгүүлбэрээр ярих</li> <li>- Өгүүлбэрийн янз бүрийн хэв маягийг ашиглан, ярих</li> <li>- Бусдад асуулт тавих, бусдын асуултад хариулах</li> <li>- Хэл зүгшрүүлэх үг, түргэн хэллэг, жороо үг хэлэх замаар хэлэхэд төвөгтэй авиа, үг, хэвшмэл хэллэгийг хэлж сурах</li> <li>- Цэгцтэй (логик), дэлгэрэнгүй өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сонссон, уншсан зүйлийн гол утга, санааг олж ярих</li> <li>- Уран уншлага сонсож, үгийн өргөлт, дуу хоолойны өнгө, нарийн бүдүүн, чанга сул, аялгуу хөгийг хэрхэн тохируулж уншиж байгааг ялган таних</li> <li>- Уншсан, сонссон эхээс эш татан ярих</li> <li>- Ярианы соёл эзэмших (сул үг, харь үг, этгээд үг, албаны үг, бүдүүлэг үг, хар ярианы хатуу үг хэлэхгүй цээрлэх)</li> <li>- Тухайн орчин нөхцөлд тохируулан ярих</li> <li>- Харилцагчийнхаа ярианы гол санаа, өнгө аясыг ойлгох</li> </ul>
<i>Харсан, сонссоноо ярих</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Зурагт эхийг тайлбарлан ярих, асуулт зохиох</li> <li>- Харсан сонссоноо тогтоож ярих, магадлах, лавшруулж асууж ярилцах</li> <li>- Яриаг анхааралтай сонсож, чухал хэсгийг мэдэх</li> <li>- Харсан, сонссон зүйлийнхээ дотроос өөрт таалагдсан зүйлээ ярих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цуврал зургийн үйл явдлыг дарааллаар ярих</li> <li>- Уншсан, сонссон, үзэж харснаа ярих</li> <li>- Өөрт тохиолдсон явдал, уншсан, сонссон эхийн үйл явдлыг дарааллын дагуу ярих</li> <li>- Бусдын яриаг идэвхтэй, анхааралтай сонсож ойлгох</li> <li>- Үндэсний онцлогийг илтгэсэн үг хэллэгийг тогтоох, ойлгох (гэр, малын тухай үгс)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Харсан, сонссон зүйлээ товч тодорхой, оновчтой ярих</li> <li>- Үзсэн киноны үйл явдлыг өөрийн үгээр ярих</li> <li>- Харсан, сонссон зүйлийг өөрийн бодолтой харьцуулан ярих</li> <li>- Үндэсний онцлогийг харуулсан үг хэллэгийг тогтоох, ойлгох, яриандаа хэрэглэх (монгол хувцас, зан заншил...)</li> </ul>
<i>Хамтран ажиллах, харилцах</i>	<ul style="list-style-type: none"> <li>-Уламжлалт мэндчилгээний үг хэллэгийг хэрэглэж харилцах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Гадаад хэлний орчинд эх хэлээрээ саадгүй ярих</li> <li>- Асуултад хариулахдаа өөрийн санааг бүрэн гүйцэд, цэгцтэй илэрхийлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Гадаад хэлний орчинд эх хэлээрээ ярихдаа мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ илэрхийлэх</li> </ul>

<i>“Унших” чадвар</i>			
	<i>Анхан</i>	<i>Дунд</i>	<i>Ахисан</i>
<i>Зөв унших</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэдэвт зургийн үйл явдлыг зөв унших</li> <li>- Зургийн үйл явдлыг ярилцах</li> <li>- Сурсан шүлгээ унших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эгшиг, гийгүүлэгч, үе, үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг зөв унших</li> <li>- Урт, богино, хос эгшгийг ялгаж унших</li> <li>- Асуух, анхааруулах, хүүрнэх өгүүлбэрийн аялгыг зөв дуудаж унших</li> <li>- Үг, холбоо үг, өгүүлбэр, бичил эхийг ойлгож унших</li> <li>- Түгдрэлгүй, ойлгомжтой унших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Шүлгийг чээжилж, уран яруу унших</li> <li>- Эхийг зөв аялгатай, ойлгомжтой, утгыг гарган унших</li> <li>- Харилцан яриаг дүрд хувиран сэтгэл хөдлөлийг гарган унших</li> <li>- Эхээс сонирхсон хэсгээ сонгон унших</li> <li>- Уншсан эхийнхээ гол санааг тодруулж унших</li> </ul>
<i>Үгийн утгыг ойлгох</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэдвээс ойлгохгүй үгсийн утгыг тааварлах</li> <li>- Өгөгдсөн сэдвийн хүрээнд танил биш, ойлгомжгүй үгийн утгыг асууж мэдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хялбар толь бичиг ашиглан, мэдэхгүй үгийн утгыг олох</li> <li>- Хам сэдвийн хүрээнд үгийн утгыг тайлбарлах</li> <li>- Дуудлага ижил үгийн утгыг ялган тайлбарлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үг салаа утгатай байдгийг мэдэх</li> <li>- Үгийн үндсэн ба шилжсэн утгыг ойлгох</li> <li>- Өгсөн үгээр үгийн үүр үүсгэх (Жишээ: явах-зорчих, хөдлөх, одох гм.)</li> </ul>
<i>Эхийн агуулыг ойлгож унших</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Зурагт эх болон цуврал зургийн агуулгыг ойлгох</li> <li>- Үйл явдлыг таамаглан зургийг унших</li> <li>- Зургийн үйл явдалд тохирсон асуулт асуух, хариулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхийн агуулгыг ойлгож унших</li> <li>- Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгаж унших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхийн гол санааг олж унших</li> <li>- Гол санааг өөрийн бодолтой харьцуулах</li> <li>- Эхээс чухал ба чухал бусыг олж тэмдэглэх</li> <li>- Эхээс өөрт хэрэгтэй мэдээллийг олж танилцуулах</li> </ul>
<i>Сонгон унших</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрт таалагдсан зурагт эхийг сонгон унших, ярих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхээс тодорхой хэсгийг зорилготойгоор сонгож ойлгон унших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Танин мэдэхүйн болон сонирхлын дагуу ном сонгож унших</li> </ul>
<i>Уран зохиолын эх унших</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Богино шүлэг, зүйр цэцэн үг, оньсого, ертөнцийн гурвыг чээжлэх</li> <li>- Ерөөл, магтаал чээжлэх</li> <li>- Сонссон үлгэр, домог, өгүүллэг, эхийн утгыг тогтоож, ярих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхийг өөртөө болон бусдад унших</li> <li>- Шүлгийг уран тод, мэдрэмжээ илэрхийлэн унших</li> <li>- Зохиолын үйл явдал болон зохиолын баатрын зан байдлыг сонгон унших</li> <li>- Оньсого, тааврыг унших, чээжлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зохиолын баатруудын харилцан яриаг сонгож унших, тайлбарлах</li> <li>- Шүлэг, яруу найраг уншихдаа мэдрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлж унших</li> <li>- Жүжгийн зохиолыг ойлгон уншиж, дүрээр илэрхийлэх</li> <li>- Эхийн үйл явдлын дарааллыг олж унших</li> </ul>
<i>Хэрэглээний эх унших</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Зураг хэлбэрээр өгөгдсөн зааврыг уншиж ойлгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өргөн хэрэглээний нэр, хаягийг уншиж ойлгох</li> <li>- Шошго, зарыг унших</li> <li>- Хүснэгт, графикан мэдээллийг унших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Урилга, захидал, илгээмж унших</li> <li>- Танилцуулга, зааврыг уншиж ойлгох</li> </ul>

	<i>“Бичих” чадвар</i>		
	<i>Анхан</i>	<i>Дунд</i>	<i>Ахисан</i>
<i>Зөв бичих</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Кирилл цагаан толгойн үсгийн зурлагыг зөв бичих</li> <li>- Өгөгдсөн зурлагыг гүйцээх, хуулан бичих</li> <li>- Хичээнгүй бичих</li> <li>- Зурах, будах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таних</li> <li>- Хуулан бичих</li> <li>- Цагаан толгойн үсгийг дармал, бичмэл тигээр зөв бичих</li> <li>- Том үсгээр эхлэн бичих</li> <li>- Цэг цэглэлийг зөв хэрэглэх</li> <li>- Үеэр таслан, мөр шилжүүлж бичих</li> <li>- Эгшиг зохицох ёсны дагуу эр, эм үгэнд нөхцөл, дагаврыг зөв залган бичих</li> <li>- Чээжээр бичих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхээс мэдэхгүй үгийг тайлбарлан бичих</li> <li>- Эхийн агуулгыг ойлгон, дарааллын дагуу бичих</li> <li>- Уншсан эхийн утга санааг энгийн үгээр тайлбарлан бичих</li> <li>- Уншсан зүйлээ дүгнэн бичих</li> </ul>
<i>Бичих санаагаа олж төлөвлөх, зохион бичих</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Зурагт эхийн дарааллыг олж, зөв байрлуулах</li> <li>- Дарааллын дагуу бусдад ярих</li> <li>- Орон байр, цаг хугацаа заасан үсгийг хэрэглэн юмсын байршлыг тайлбарлан бичих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дуурайн бичих</li> <li>- Уншсан эх, баатрын талаар бичих</li> <li>- Уншсан эхийн үйл явдлыг дарааллын дагуу бичих</li> <li>- Өөрийн болон гэр бүлийн танилцуулга бичих</li> <li>- Өдрийн тэмдэглэл хөтлөх</li> <li>- Өгсөн зааврын дагуу зохион бичих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сонгож уншсан зохиол, эхийн үйл явдлыг хураангуйлж, товчилж бичих</li> <li>- Тодорхой сэдвээр төлөвлөгөө зохиож бичих</li> <li>- Уншсан эхийн тухай өөрийн санааг илэрхийлж бичих</li> <li>- Зохиолын баатрын хийсэн үйлдэл, зан төрхийг тодорхойлж бичих</li> </ul>
<i>Бичсэнээ хянах, сайжруулах</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Зөв бичсэн эсэхээ хянах (Бичсэн зурлагаа дуурайн бичсэн загвартай ижил болсон эсэхийг хянах, алдаагаа олох, засан сайжруулж бичих)</li> <li>-</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цэг тэмдэг, үг үсгийн алдааг олж засах</li> <li>- Бичсэн эхийн алдааг засаж, дахин бичих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бичсэн эхийн хэл найруулга, дүрмийн алдааг засах</li> <li>- Бичсэн эхийг засаж, сайжруулан сийрүүлэх</li> </ul>
<i>Хэл зүй, үгийн санг хэрэглэх</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэн? юу? яав? Зэрэг асуултад хариулагдах үсгийг ялгах</li> <li>- Жинхэнэ нэрийн олон тоог хэрэглэх</li> <li>- Ойролцоо ба эсрэг утгатай зарим үгийг ялгах, тогтоох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таних, тэдгээртэй холбоотой үсгийн дүрмийг мэдэж, зөв хэрэглэх</li> <li>- Өгүүлбэрийг асуултын дагуу дэлгэрүүлэх</li> <li>- Энгийн, хураангуй, дэлгэрэнгүй өгүүлбэрийг таних, хэрэглэх</li> <li>- Өгүүлбэрт сэтгэлийн хөдөлгөөн, өнгө аясыг илэрхийлэх (Талархал, анхааруулга, асуулт, гайхах гэх мэт)</li> <li>- Мэдэхгүй үгийн утгыг тухай бүр тайлбарлах, үгийн баялгаа нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эгшиг гээгдэх, гээгдэхгүйн тохиолдлуудыг зөв бичих</li> <li>- Тийн ялгалын нөхцөлийг зөв бичих</li> <li>- Дуудлага ижил үгийн утгыг таньж, зөв хэрэглэх</li> <li>- Өгүүлбэрийг учир шалтгааны асуултаар дэлгэрүүлэх</li> <li>- Хэлц үгийн тухай мэдэх, хэрэглэх</li> </ul>

**ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ**

- A. Монгол хэл, бичиг, соёлын сургалтын хөтөлбөрийн агуулга, хэрэглэгдэхүүн нь өдөр тутмын ахуйн харилцааны агуулга бүхий байхаас гадна монголын түүх, соёл, уран зохиол, ёс заншил, эд өлгийн зүйлстэй холбоотой төрөл бүрийн эх байна. Эхүүд нь тухайн насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, сонирхол хэрэгцээнд нийцсэн танин мэдүүлэх, хүмүүжүүлэх, хөгжүүлэх агуулгатай байна.
- B. Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх дараах зүйлсийг анхаарна. Үүнд:
- анхан, дунд, ахисан түвшний хөтөлбөрийн агуулгын залгамж холбоотой сайн танилцсан байх
  - хүүхдийн хэл, соёлын түвшинг харгалзан хөтөлбөрийн шатлалыг сонгон хэрэгжүүлэх
  - хүүхдийн ярианы хөгжил, үгийн баялаг, ярих бичих чадвар хөтөлбөрөөс хөтөлбөрт хэрхэн ахиж байгааг үнэлэх.
- C. Хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдийн эх хэлний мэдлэг, чадварын түвшин нэгэн жигд биш, харилцан адилгүй байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарч үзэх асуудал болно. Үүнд:
- Эх хэлээрээ ярьдаг боловч кирилл үсэг мэдэхгүй хүүхдийн унших, бичих чадварыг хөгжүүлэх шаардлага гарна. Тиймээс багш, эцэг, эх хүүхдийнхээ монгол хэлний мэдлэг чадварын байдалд тохирох шатлалын хөтөлбөрийг сонгон судлахад нь туслана. Тухайлбал, гадаад улс оронд төрсөн, эх хэлээ огт мэддэггүй хүүхдийн тухайд анхан шатны хөтөлбөрийн дагуу суралцах бол монгол хэлээ мэддэг, ярьдаг боловч монголоор уншиж, бичиж сураагүй хүүхдийн тухайд дунд шатны хөтөлбөрөөс эхлэн судална.
  - Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг зайлшгүй харгалзах хэрэгтэй. Учир нь дунд, ахлах ангийн хүүхэд хэдийгээр анхан шатны хөтөлбөрөөр суралцах хэрэгцээ байгаа боловч тэдний оюуны чадамж, хэл ярианы хөгжил, унших бичих хурд, ухааран ойлгох чадвар нь бага ангийн хүүхдээс өндөр байна. Иймд янз бүрийн насны хүүхэд нэг хөтөлбөрөөр хичээллэх үед сургалтын арга зүй, хүүхэд бүрээр хийлгэх үйл ажиллагаа (activity) болон түүнд зарцуулах хугацааг сайтар бодож төлөвлөх хэрэгтэй болно.
- D. Монгол хүүхдийн амьдарч буй гадаад ахуй орчин, хот суурины нөхцөл, тухайн улс орны хөгжил, хүн ардын ахуй, заншил, хөдөлмөр, хэл соёлын ялгааг сайтар анхаарвал зохино.

### *СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН (жишиг байдлаар)*

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах эх сурвалжаас сонгож ашиглана. Сонголт хийхдээ тухайн хэрэглэгдэхүүний олдоц, хүртээмж зэргийг харгалзана.

Мөн тухайн хүүхдийн монгол хэлний ерөнхий түвшинг харгалзан энгийнчлэх болон арга зүйн боловсруулалт хийж ашиглахад анхаарна.

- Монгол эд өлгийн зүйлс (монгол гэр, хувцас, хоол, тоглоом наадгай, мал аж ахуйн тоног хэрэгсэл, тэрэг чарга, дархан мужааны багаж хэрэгсэл гм)-ийн багасгасан загвар, хийц, зураг урлалын бүтээлээс ашиглах

- Монгол ардын дуу, үлгэр, домог, зүйр цэцэг үг, оньсого, таавар, үгэн наадам, ертөнцийн гурав, ерөөл магтаал, зан үйлийн аман зохиолын түүвэр, эмхтгэл, дээж бичиг
- Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгүүд (Монгол Улсын Үндсэн хууль, туг далбаа, сүлд, тамга, мөнгөн тэмдэгт гэх мэт)
- Эх орны сэдэвт дуу, шүлэг. Тухайлбал, Д.Нацагдоржийн "Миний нутаг", "Дөрвөн цаг" шүлэг, Ц.Дамдинсүрэнгийн "Монгол нутаг" шүлэг, Ж.Бадраагийн "Халуун элгэн нутаг" дуу, Ч.Чимид "Би монгол хүн" шүлэг, Д.Пүрэвдорж "Тусгаар тогтнол" найраглал, П.Бадарчийн "Есөн эрдэнийн орон" шүлэг гэх мэт.
- Түүхэн буюу сургаалын уран зохиол. Тухайлбал, Лувсанданзангийн "Алтан товч", "Эрдэнийн эрхи", А.Амар "Монголын түүх", "Монголын нууц товчоо", "Чингисийн 9 өрлөгтэй өнчин хөвүүний цэцэлсэн шастир", "Чингисийн билиг сургаал", "Оюун түлхүүр", "Тодорхой толь", "Тоть шувууны сургаал", "Авах гээхийн 4 мөрт шүлгүүд", Ишданзанванжил "Гүнгийн зуугийн гэгээний сургаал", То.ван хэмээх Тогтохтөрийн "Аж төрөхийг заасан сургаал", Равжаагийн "Цаасан шувууны сургаал", "Ертөнц авхайн жам", "Саваагүй хүүхэд гайхал хоёрын хэлэлцсэн үгс", Ч.Дандаа "Эрдэнэт толь", Ч.Бат-Очир "Мандах нарны туяа", Ж.Самбуу "Малчин ардад өгөх сануулга сургаал", Д.Чойжилсүрэн "Сургаалын өглөг" гм.
- Түүхэн хүмүүсийн намтар, тэдний монголын түүхэнд байгуулсан гавьяа, үлдээсэн өв сургаал, сургамж туршлага. Тухайлбал, Чингис, хаан түүнийг залгамжлагчид, Мандухай сэцэн хатан, Галдан Бошигт хаан, Ану хатан, Чингүнжав, Амарсанаа, Занабазар, VIII Богд хаан, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Ж.Батмөнх, С.Зориг гэх мэт.
- Ч.Арьяасүрэн нарын "Монгол зан заншлын их, дунд, бага тайлбар толь", Х.Нямбуу "Хамгийн эрхэм ёс", "Цээрлэх ёс", Н.Нагаанбуу нарын "Монгол ёс заншил, утга бэлгэдэл, хорио цээрийн тайлбар толь", "Монголын хүүхдийн нэвтэрхий толь" /шинэчилсэн 3 боть/ гэх мэт.
- Цахим хэрэглэгдэхүүн:
  - [www.mecss.gov.mn](http://www.mecss.gov.mn) - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам. "Бага, дунд боловсрол" гэсэн хэсгээс бүх сурах бичгийг харах боломжтой.
  - [www.itpd.mn](http://www.itpd.mn) – Багшийн мэргэжил дээшлүүлэх институт. Багшлах эрх, үндсэн сургалт зэрэг гол мэдээллүүдийг авах боломжтой.
  - [www.teacher.sur.mn](http://www.teacher.sur.mn) – БСШУС-ын Яам, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Багшийн хөгжил портал сайт
    - Онлайн хичээл
    - "Мультимедиа програм хангамжийг сургалтад хэрэглэх, хөгжүүлэх нь" уралдааны бүтээлүүд
    - Боловсролын салбарын шинэ мэдээ, мэдээлэл
  - [www.urchadvar.itpd.mn](http://www.urchadvar.itpd.mn) - Хичээлийн сайн технологи (797 видео хичээлийн сан)
  - [www.mn.khanacademy.org](http://www.mn.khanacademy.org) - Багш, сурагч, эцэг эхчүүдийн системтэйгээр шатлан сурах нээлттэй сургалт
  - [mn.childrenslibrary.org](http://mn.childrenslibrary.org) – Хүүхдийн уран зохиолын ном
  - БСШУСЯ., "Би монгол хүн" DVD

**ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ**



Хөтөлбөрийн хэрэгжилтийг шатлал бүрээр үнэлэх бөгөөд үнэлгээний шалгуурыг боловсруулахад дараах зөвлөмжийг баримтална. Үүнд:

- Анхан шатны хөтөлбөрөөр хүүхдийн сонсох, ярих чадварын байдал, ахиц, хөгжлийг үнэлнэ. Асуултын шинж чанар, утга агуулгыг хэр ойлгож байгаа, асуултанд үнэн зөв хариулж байгаа эсэх, харилцан ярихдаа бусдыг сонсох чадвар болон бусдад асуулт тавьж байгаа байдал гм. Мөн монгол хэлний авиаг зөв, тод, чанга дуудаж, үг өгүүлбэрийг зөв, хурдан, бүрэн хэлэх байдал, ярихдаа дууны өнгө, аялга, өргөлтийг тохируулж байгаа эсэх, бүтэн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх чадвар, харилцаандаа биеийн хэл /дохио зангаа, нүүрийн хувирал, нүдний харц, гар хурууны хөдөлгөөн гм/-ийг оновчтой зөв хэрэглэх, үгийн баялаг нэмэгдэж байгаа байдал.
- Дунд шатны хөтөлбөрийн түвшинд кирил бичгээр уншиж, бичиж сурах бөгөөд энэ чадварыг үнэлэхдээ унших эхийг түгдрэлгүй хурдан, зөв унших, уншсанаа ойлгох, ойлгосноо ярих, тайлбарлах чадвар, эхийг хичээнгүй сайхан хуулан бичих, алдаагүй зөв бичих (чээж бичиг) чадварыг үнэлнэ. Уламжлалт минутын уншлага хийж дүгнэх ба чээж бичиг, хуулан бичиг, зохион бичлэг бичүүлж дүгнэхдээ нэг минутанд уншсан үгийн тоо, дүрмийн болон утга найруулгын алдааг тоолж үнэлнэ.
- Ахисан шатны хөтөлбөрөөр бичил эхийг дэлгэрүүлэх, дэлгэрэнгүй эхийг хурааж бичих, уншсан эхээс найруулан бичих, өгсөн сэдвээр бичил эх зохион бичих (их төлөв хүүрнэмж, тоочимж эх зохиох) зэрэг чадварыг үнэлнэ. Мөн монголынхоо түүх, соёл, заншил, ахуй амьдралтай танилцах, судлах, эх түүх соёлоо бахархан дээдлэх, хайрлан хамгаалах, хадгалан хөгжүүлэх эх оронч иргэнлэг үзэл хүмүүжлийг хүүхдэд хүртээх бөгөөд энэ чадварыг үнэлэхдээ эх хэлээрээ унших, бичих, ярих, тайлбарлах, мэтгэлцэх чадварын ахиц хөгжлийг үнэлж болохоос гадна монгол сэтгэлгээ, үндэсний үзэл, эх оронч хүмүүжил, зөв монгол хүн болж буй төлөвшил хандлагыг үнэлж дүгнэнэ.

.....0 0 0.....